



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/135

Хэрлэн сум

Аймгийн "Хүндэт тэмдэг" болон
"Хан Хэнтийн алдартан тэмдэг"-ийг хийлгэх
зардалд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2003 оны А/99, 2015 оны А/511 тоот захирамж, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймаг нийслэлийн Засаг даргаас олгох шагналын нийтлэг тодорхойлолт"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий нутгийн хөгжлийн төлөө онцгой амжилт гаргасан иргэдийг шагнах аймгийн "Хүндэт тэмдэг" болон "Хан Хэнтийн алдартан тэмдэг"-ийг хийлгэх зардалд 12,480,000 (арван хоёр сая дөрвөн зуун наян мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010372

Аймгийн Засаг даргын 2022 оны
..... дугаар сарын өдрийн
..... захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Хан Хэнтий алдартан медаль	ш	300	19,500	5,850,000
2	Үнэмлэх	ш	300	2,300	690,000
3	Хүндэт тэмдэг	ш	300	17,500	5,250,000
4	Үнэмлэх	ш	300	2,300	690,000
	Нийт дүн				12,480,000